



# СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ

*ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ*



2010 онд

## ГАРЧИГ

I. Аймгийн эдийн засаг, нийгмийн зарим гол үзүүлэлтүүд

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл  
( эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар )

Нэг. Хүн ам

- 1.1 Хүн амын тоо, хүйс, байршлаар, оны эцэст
- 1.2 Суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, оны эцэст
- 1.3 Суурин хүн амын сумаар, хүйсээр, оны эцэст
- 1.4 Суурин хүн амын нас, хүйсний бүтэц, хувиар, оны эцэст
- 1.5 Суурин хүн амын тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.6 Өрхийн тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.7 Хүн амын тоо, сумаар, байршлаар, 2010 онд
- 1.8 Хүн амын тоо, сумаар, насны ангиллаар, 2010 онд
- 1.9 Хүн амын төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт, сумаар, оны эцэст
- 1.10 Хүн амын дундаж наслалт, аймаг, улсын дундаж
- 1.11 Төрсөн, нас барсан, гэрлэсэн, гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо, оны эцэст
- 1.12 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт, оны эцэст
- 1.13 Төрөлтийн коэффициентүүд насны бүлгээр, оны эцэст
- 1.14 Нас барсан хүний тоо, насны бүлгээр, оны эцэст
- 1.15 Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр, оны эцэст
- 1.16 1000 хүн амд ногдох төрөлт сумаар, оны эцэст
- 1.17 1000 хүн амд ногдох нас баралт, сумаар, оны эцэст
- 1.18 Үрчлэлт, хүүхдийн насны бүлгээр, оны эцэст
- 1.19 Бүртгүүлсэн гэр бүлийн тоо, оны эцэст
- 1.20 Гэрлэлтээ цуцлуулсан гэр бүлийн тоо, оны эцэст
- 1.21 Хүн амын шилжилт хөдөлгөөн, оны эцэст
- 1.22 Хүн амын шилжилт хөдөлгөөн, шилжилт хийгдсэн аймаг нийслэлээр
- 1.23 Өрхийн тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.24 Өрхийн нийгмийн зарим үзүүлэлт, сумаар, оны эцэст
- 1.25 Хүн амын нийгмийн зарим үзүүлэлт, сумаар, оны эцэст

Хоёр. Ажиллах хүч

- 2.1 Хүн амын ажил эрхлэлтийн үзүүлэлт, оны эцэст
- 2.2 Ажиллагчдын тоо, сумаар, оны эцэст
- 2.3 Ажиллагчдын тоо, салбарын ангилалаар, оны эцэст
- 2.4 Эдийн засгийн идэвхитэй хүн ам, сумаар, оны эцэст
- 2.5 Төрийн албан хаагчдын тоо, төрийн албаны ангиллаар, оны эцэст
- 2.6 Ажиллах хүчний зарим үзүүлэлтүүд, сумаар, оны эцэст
- 2.7 Бүртгэлтэй ажилгүйчүүд, сумаар, оны эцэст
- 2.8 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сумаар, насны бүлгэр
- 2.9 Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд, бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон хүний тоо, сумаар
- 2.10 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, боловсролын түвшинээр, оны эцэст
- 2.11 Шинээр бий болгосон ажлын байр, салбарын ангилалаар, 2010 онд

Гурав. Дотоодын нийт бүтээгдэхүүн

- 3.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр
- 3.2 Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, 2006-2010 он, оны үнээр. мян төг

Дөрөв. Хөдөө аж ахуй

- 4.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
- 4.2 ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
- 4.3 Мал сүргийн өсөлтийн үзүүлэлт
- 4.4 Малын тоо, сумаар, төрлөөр
- 4.5 Малчдын тоо, сумаар, мал тооллогын дүнгээр
- 4.6 Малчин өрхийн нийгэм ахуйн зарим үзүүлэлт
- 4.7 Малчин өрхийн малын бүлэглэлт, мал тооллогын дүнгээр
- 4.8 Газар тариалангийн үйлдвэрлэл
- 4.9 газар тариалангийн үйлдвэрлэл сумаар
- 4.10 1000-с дээш малтай өрхийн судалгаа
- 4.11 Аймгийн хэмжээнд 5-н төрлөөр хамгийн олон малтай сум
- 4.12 Аймгийн хэмжээнд 5-н төрлөөр хамгийн олон малтай баг
- 4.13 Аймгийн хэмжээнд 5-н төрлөөр хамгийн олон малтай өрх
- 4.14 Малын тоо толгой хүрсэн дээд хэмжээ
- 4.15 2010 онд шинээр гаргасан худгийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ
- 4.16 2010 онд сэргээн засварласан худгийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ
- 4.17 Цаг уурын үзүүлэлтүүд
- 4.18 Багуудын зарим үзүүлэлтүүд, оны эцэст

Тав. Аж үйлдвэр

- 5.1 Нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр
- 5.2 Нийт бүтээгдэхүүн ба борлуулсан бүтээгдэхүүн, оны үнээр, оны эцэст
- 5.3 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлөөр, аймгийн дүнгээр
- 5.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлөөр, сумаар, оны эцэст
- 5.5 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, сумаар, оны эцэст
- 5.6 Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, салбар, дэд салбараар, оны үнээр, мян.төг
- 5.7 Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж, салбар, дэд салбараар, оны үнээр

Зургаа. Барилга угсралт

- 6.1 Барилга угсралт, их засварын ажил, оны эцэст

- 6.2 Гүйцэтгэсэн барилга угсралт , их засварын ажил, объектын нэрээр, сая.төг
  - Долоо. Тээвэр , холбоо
    - 7.1 Авто тээвэр, оны эцэст
    - 7.2 Холбоо, шуудан, оны эцэст
    - 7.3 Үүрэн телефон, оны эцэст
    - 7.4 Кабелийн телевиз, оны эцэст
    - 7.5 Телефон утасны сүлжээний байршил, 2010 оны 12-р сарын 31-ны байдлаар
    - 7.6 Нефть хангамж, оны эцэст
  - Найм. Дотоод худалдаа, нийтийн аж ахуй
    - 8.1 Худалдаа, зочид буудал, зоогийн газрын борлуулалтын орлого, оны эцэст
    - 8.2 Хот нийтийн аж ахуйн үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, оны эцэст
    - 8.3 Хо, нийтийн ахуйн үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, сумаар, оны эцэст
  - Ес. Орон сууц
    - 9.1 Ашиглалтанд оруулсан орон сууц, м2, оны эцэст
  - Арав. Боловсрол , соёл, урлаг
    - 10.1 Бүх шатны сургуульд суралцагсад, хичээлийн жилд
    - 10.2 Бүх шатны сургуульд элсэгчид, хичээлийн жилд
    - 10.3 Бүх шатны сургууль төгсөгчид, хичээлийн жилд
    - 10.4 Соёл урлаг
  - Арван нэг. Хүн амын эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ
    - 11.1 Эрүүл мэндийн байгууллагын үзүүлэлт, оны эцэст
    - 11.2 Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, ажил мэргэжлээр
    - 11.3 Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо, сумаар
    - 11.4 Нэг эмчид ногдох хүний тоо, сумаар
    - 11.5 Нялхсын эндэгдэл, сумаар
    - 11.6 Эмнэлгийн орны тоо, сумаар
    - 11.7 Нийгмийн халамжийн тэтгэмжид хамрагдсан хүний тоо, оны эцэст
    - 11.8 Нийгмийн халамжаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж
    - 11.9 Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр тэтгэмж, даатгуулагчдын тоо
  - Арван хоёр. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо
    - 12.1 Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
    - 12.2 Аж ахуйн нэгж байгууллагын тоо, сумаар, үйл ажиллагаа эрхлэлтээр
    - 12.3 Аж ахуйн нэгж, байгууллагын тоо /2000-2010 он /
  - Арван гурав. Аймгийн нэгдсэн төсөв
    - 13.1 Орон нутгийн төсвийн орлого, оны эцэст
    - 13.2 Орон нутгийн төсвийн байгууллагын зарлага, зардлын зүйлээр
    - 13.3 Орон нутгийн төсвийн орлого, сумаар
    - 13.4 Орон нутгийн төсвийн зарлага, сумаар
    - 13.5 Улсын нэгдсэн төсөвт төврүүлсэн орлого, оны эцэст
    - 13.6 Улсын төсвийн байгууллагын зарлага, зардлын зүйлээр
    - 13.7 Улсын төсвийн байгууллагын зарлага, төсвийн ерөнхийлөн захирагчаар
  - Арван дөрөв. Зээл, мөнгөн гүйлгээ
    - 14.1 Мөнгөн гүйлгээ, оны эцэст
    - 14.2 Банкуудын нэгдсэн үзүүлэлт, оны эцэст
    - 14.3 Зээл, салбараар, оны эцэст
    - 14.4 Хадгаламж, зээлийн жилийн хүү, оны эцэст
  - Арван тав. Үнэ
    - 15.1 Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс
    - 15.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тариф
    - 15.3 ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ
    - 15.4 ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ
    - 15.5 Гол нэрийн барааны үнэ, говийн бүсийн аймгуудаар
    - 15.6 Улаанбаатар хотод зарагдаж байгаа авто бензин, дизел түлшний үнэ, 2010 оны 12-р сарын 29ны байдлаар
    - 15.7 Аймгийн төвүүдэд зарагдаж буй автобензин, дизел түлшний үнэ
  - Арван зургаа
    - 16.1 Аймгийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал
    - 16.2 Газарт учруулсан хохирол, оны эцэст, га-гаар
    - 16.3 Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлсэн газар, сумаар
    - 16.4 Эзэмшиж, ашиглаж байгаа газар олголт
    - 16.5 Газрын төлбөр
    - 16.6 Байгал орчны төлөв байдал, оны эцэст
  - Арван долоо. Гэмт хэрэг
    - 17.1 Бүртгэгдсэн хэргийн тоо, хэргийн өнгөөр
    - 17.2 Бүртгэгдсэн хэргийн тоо, сумаар
    - 17.3 Малын хулгайн хэргийн тоо, сумаар
    - 17.4 18-с дээш насны 1000 хүнд ногдох гэмт хэргийн тоо, сумаар
    - 17.5 Гал түймрийн тоо, учирсан хохирол, шалтгаан, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ
- Тэмдэглэлийн тайлбар:**
- ( ... ) - тухайн тоо баримт байхгүй
  - ( 0 ) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
  - ( x ) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
  - ( . ) - мэдээлэгдэх хугацаа болоогүй



## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2010 ОНД


(Товч танилцуулга)

### Нэг. ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


#### 1. Хүн ам

Дорноговь аймгийн хүн амын тоо 2010 оны жилийн эцэст 59.8 мянга болж 2009 оныхоос 3.6 хувиар, 2000 оны хүн амын тооллогоос 18.2 хувь буюу 9.2 мянган хүнээр өсөв. Аймгийн хүн амын тоо 2000 оны тооллогоос хойш жилд дунджаар 1,87 хувиар өсчээ.

Зураг. Аймгийн хүн амын тоо, хүн амын тооны өсөлтийн хувь




Зураг. Хүн амын тооны жилийн дундаж өсөлт, хувиар



Хүн амын тоогоор эхний 5 –д Сайншанд (21.1 мянга), Замын-Үүд (13.8 мянга), Айраг (3.6 мянга), Хатанбулаг (3.1 мянга), Даланжаргалан, Эрдэнэ (2.6 мянга) сум орж байна.

Хүн амын жилийн дундаж өсөлт Замын-Үүд суманд хамгийн өндөр байна. Тус сумын хүн амын тооны өсөлт 1995 оноос эрчимжиж 2000 оноос хойш жилд дунджаар 10.8 хувиар өсч 2010 оны эцэст 13.8 мянган байнгын оршин суугчтай болжээ.

Зураг. Хүн амын тооны жилийн дундаж өсөлт, хувиар, сумаар, 2000-2010 онд



Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын Үүд сумдад 2000 оноос хойш жилд дунджаар 0.42-10.79 хувиар өссөн бол бусад сумдад 0.41-2.56 хувиар буурчээ. Өөрөөр хэлбэл иргэд төв, суурин газар руу шилжих нь элбэгшсэн байна.

2009 оны жилийн эцсийн хүн амын тоотой харьцуулбал Алтанширээ, Иххэт, Мандах, Улаанбадрах сумаас бусад 10 сумын хүн амын тоо өсөв.


Хүн амын нас, хүйсний бүтцэд өөрчлөлт ажиглагдаж байна. 2000 онд хүн амын 38.8 хувийг хүүхэд (0-15 нас), 55.9 хувийг хөдөлмөрийн насны (16-59 нас), 5.3 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзэлж байсан бол хүн амд хүүхэд, өндөр настны эзлэх хувь жилээс жилд



буурсаар 2010 оны эцэст 28.4 хувийг хүүхэд, 66.8 хувийг хөдөлмөрийн насны, 4,8 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзлэх болжээ. Хүн амын нас, хүйсний суврагаас харахад 2000 оныхоос 2010 онд суврагын гол хэсэг өргөсөж доод дээд хэсгээрээ нарийссан нь дээрхи дүгнэлтийг харуулж байна.

2000 оны хүн ам, орон сууцны тооллогоос хойш хүйсний харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) буурч байснаа 2007 оноос эхлэн нэмэгдэж 2010 онд 99.3 болжээ. Хүйсний харьцааг насны бүлгээр аймгийн ерөнхий дүнгийн дундажтай харьцуулж үзвэл 0-39 насанд илүү байгаа бол 40-өөс дээш насанд бага байна. Энэ нь 40-өөс дээш насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс илүү байдгийг илэрхийлж байна.

Зураг. Дорноговь аймгийн хүн амын нас, хүйсний суврага 2000.2010 он



Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг юм. Хүн ам зүйн ачаалал 1979 онд 142.3%, 1989 онд 116.0%, 2000 онд 78.8% болж тооллогоос тооллогын хооронд буурч ирсэн бол 2010 онд 49.8 хувьд хүрч 2009 оноос 2.1 пунктээр өслөө.


Нийт хүн амын 60.6 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 15,2 хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд амьдарч байна. Хот тосгонд амьдарч байгаа хүний эзлэх хувь өмнөх оноос 0.7 пунктээр, 2000 оны тооллогоос 10,8 пунктээр нэмэгджээ.

109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 59.8 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.55 хүн ногдож байна. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дунджаас дээгүүр байна.

Хүн амын тооны өсөлтийн 48.9 хувийг ердийн өсөлтөөр, 51,1 хувийг механик өсөлт буюу шилжин ирэгсдийн тооны өсөлтөөр хангасан байна.

2010 онд Дорноговь аймагт 693 хүү, 653 охин нийт 1346 шинэ хүн мэндэлж, 349 хүн нас баржээ. Өмнөх онтой харьцуулбал төрсөн хүүхдийн тоо 6.4 хувиар, нас барсан хүний тоо 20.8 хувиар өслөө. Төрсөн хүүхдийн хүйсний харьцаа 106.1, нас барсан хүний хүйсний харьцаа 177.0 байна. Нас барсан хүмүүсийн дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх оныхоос 7,8 пунктээр өсчээ.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2001-2010 он





Хүн амын шилжих хөдөлгөөн нь аймаг, сумын хүн амын тооны өсөлт, өөрчлөлтийг илэрхийлдэг үндсэн үзүүлэлтийн нэг юм. 2010 онд Дорноговь аймагт 409 өрхийн 1777 хүн шилжин ирж, 322 өрхийн 1523 хүн шилжин явснаар цэвэр шилжилт өмнөх оноос эерэг урсгалаар 4,6 дахин нэмэгдэв. Шилжилт хөдөлгөөнд оролцогсдын 79.8 хувь нь хөдөлмөрийн насны хүн, 16.2 хувь нь хүүхэд, үлдэх 4.1 хувь нь тэтгэвэрийн насныхан эзэлж, хөдөлмөрийн насныхны эзлэх хувь нэмэгдсэн байна. Шилжин ирэгсдийн дүнд эмэгтэйчүүд 50.0 хувийг эзэлж байхад шилжин явагсдын дүнд эзлэх хувь 51.7 байна.

Шилжилт хөдөлгөөний урсгал 2005-2008 онд эерэг чиглэлтэй байсан бол 2009 онд бусад аймаг, нийслэл рүү чиглэсэн сөрөг чиглэлтэй, цэвэр шилжилт нь хасах тэмдэгтэй байжээ. 2010 онд шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент +0.42 болж өмнөх оноос 0,55 пүнктээр нэмэгдэв.


Нийт шилжин явсан хүн амын 56.6 хувь нь Улаанбаатар руу, 7.0 хувь нь Өмнөговь аймаг руу шилжсэн, харин шилжин ирэгсдийн 44.0 хувь нь Улаанбаатараас, 6.7 хувь нь Сүхбаатар аймгаас тус тус шилжин ирсэн нь хамгийн өндөр хувь байна.

## 2. Өрхийн зарим үзүүлэлт

2010 оны эцэст 17796 өрхтэй болсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 3.6 хувиар буюу 626 өрхөөр нэмэгдсэн ч нэг өрхөд ногдох хүний тоо өмнөх оны хэмжээнд буюу 3.36 байна. 2000 оны тооллогоор нийт өрхийн 49.4 хувь нь хотод, 50.6 хувь нь хөдөөд амьдарч байсан бол 2010 онд 60,4 хувь нь аймгийн төв, тосгонд, 39.6 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байгаа нь хотожсон аймаг болохыг харуулж байна.


2010 онд 16 хүртэл насны 4-өөс дээш хүүхэдтэй өрхийн тоо 25.9 хувиар, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 5.5 хувиар, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 1.6 хувиар буурч, өндөр настай, ганц бие өрхийн тоо 20.5 хувиар, 8 түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо 24.3 хувиар өсчээ.

Зураг. Өрхийн нийгмийн зарим үзүүлэлт. 2004-2010 он



АДТДО-той өрхийн тоо 2024 болж өмнөх оноос 22.4 хувиар, өрхөд амьдарч буй хүн амын тоо 7828 болж 20.6 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарчээ. АДТДО-той өрхийн тоо Хатанбулаг суманд 13.3 хувиар нэмэгдэж, бусад суманд 8.5-53.6 хувиар буурлаа

Зураг. Нийт өрхөд АДТДО-той өрхийн эзлэх хувь, сумдаар



Зураг. АДТДО-той өрх, үүнээс аймгийн төвд





АДТДО-той өрхийн нийт өрхдөө эзлэх хувийг сумдаар харахад Хөвсгөл суманд хамгийн өндөр буюу 29.9 хувь байгаа бол Дэлгэрэх суманд 3.3 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байна.

АДТДО-той өрхийн 37.0 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй, 0.7 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 12.1 хувь нь өндөр настан тэргүүлэгчтэй өрх, хувь нь ганц бие өндөр настан тэргүүлэгчтэй өрх, хувь нь байна.

АДТДО-той өрхөд амьдарч буй хүн амын насны бүтцийг авч үзвэл хүүхэд (0-15 нас) 35.6 хувь, хөдөлмөрийн насны хүн ам (16-59 нас) 60.4 хувь, тэтгэврийн насны хүн ам 4.0 хувийг эзэлжээ. Хөдөлмөрийн насны хүн амын 17.7 хувь, хүүхэд, өндөр настны 12.1 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 1812 болж өмнөх оныхоос 0.6 хувиар буурлаа. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.6 хувийг 0-15 насны хүүхэд эзэлж байна.

Өнчин хүүхдийн тоо 2010 онд 787 болж өнгөрсөн оноос 5.9 хувиар буурав. Нийт өнчин хүүхдийн 6.5 хувь буюу 51 нь бүтэн өнчин, 93.5 хувь буюу 736 нь хагас өнчин хүүхдүүд байна.

### Хоёр. АЖИЛЛАХ ХҮЧ

#### 1.Ажиллагсад

2010 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 39940, эдийн засгийн идэвхитэй хүн ам /ЭЗИХА/-ын тоо 22147 болжээ. Өмнөх онтой харьцуулбал хөдөлмөрийн насны хүн амын тоо 4.3 хувиар, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 6.9 хувиар тус тус өсчээ.

Эдийн засгийн идэвхитэй хүн амын 97.1 хувь буюу 21505 ажиллагсад байна. Ажиллагсдыг ажиллаж байгаа салбарын ангиллаар нь авч үзвэл 31.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 5.8 хувь нь уул уурхай, олборлох, боловсруулах, аж үйлдвэрийн салбарт, 26.4 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 13.3 хувь нь тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарт, 20.0 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллаж байна.

*Зураг. Ажиллагсдын тоо салбарын ангиллаар, 2010 он*



Засаг захиргааны бүртгэлд үндэслэсэн ажил эрхлэлтийн 2010 оны жилийн эцсийн тайлангаар хөдөлмөрийн насны 18.6 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаагаас 0.6 мянган хүн буюу 3.5 хувь нь ХХҮХ-т бүртгэлтэй ажилгүйчүүд, 3.2 мянган хүн буюу 17.2 хувь нь хүүхэд, өндөр настан асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлог зэрэг хүндэтгэх шалтгаанаар, 5.1 мянган хүн буюу 27.3 хувь нь бусад шалтгаанаар, 2.0 мянган хүн буюу 10.8 хувь нь хөдөлмөрийн чадваргүйн улмаас, 7.7 мянган хүн буюу 41.2 хувь нь суралцаж байгаагаас ажил эрхлээгүй гэсэн дүн гарав.



## 2. Ажилгүй иргэд

Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст (ХХҮХ) бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2010 оны жилийн эцэст 642 байгаа нь өмнөх сараас 0.6 хувиар буурч, 2009 оны жилийн эцсийнхээс 20.7 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэний 19.8 хувь нь урьд өмнө ажил эрхэлж байсан ба 80.2 хувь нь анх удаа ажил эрж байгаа ажилгүй иргэн байна.

*Зураг. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэн, ажилд зуучлагдан орсон хүний тоо. 2005-2010 он*



2010 онд 916 хүн шинээр бүртгүүлсэн ба бүртгэлтэй ажилгүй иргэдээс 795 хүн ажилд зуучлуулан оржээ. Ажилд зуучлагдан орсон хүний тоо өнгөрсөн оноос 16.8, шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэний тоо 30.7 хувиар буурсан байна.

Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн хүйсний бүтцийг авч үзвэл 66.5 хувь буюу 427 нь эмэгтэйчүүд, 33.5 хувь буюу

215 нь эрэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдэд эзлэх эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 3.0 пунктээр буурчээ. Насны бүтцийг харвал 16-35 насны залуучууд 68.2 хувийг эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 71.7 хувийг бүрэн дунд түүнээс доош боловсролтой иргэд эзэлжээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн дунд бүрэн дундаас доош боловсролтой иргэд, залуучуудын эзлэх хувь 1.1-4.9 пунктээр өсчээ.


2010 онд 1332 иргэн шинээр ажилд орсны 63.3 хувь нь байнгын ажлын байртай болжээ. Ажилд орсон иргэдийн ажлын байрыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үзвэл уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарт 31.8 хувь, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбарт 26.5 хувь, боловсролын салбарт 10.6 хувь бусад салбарт 31.2 хувь нь ажилд оржээ.

## Гурав. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

### 1. Хөдөө аж ахуй

2010 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1056.8 мянган толгой мал тоологдсоны дотор 28.1 мянган тэмээ, 77.4 мянган адуу, 40.4 мянган үхэр, 421.3 мянган хонь, 489.6 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо 2009 оныхоос 1.9 хувь буюу 20.1 мянган толгойгоор буурчээ.

*Зураг. Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.тол*



Жил бүрийн эцсийн мал тооллогын дүнгээс харахад аймаг байгуулагдсан 1932 оноос хойш 15 дах жилдээ 1 саяас илүү мал тоологдлоо. 2010 оны эцэст тэмээ 7.8 %, адуу 6.3 %, үхэр 1.2 %, хонь 3.1 %-иар өсч, харин ямаа 7.5 хувиар буурсан байна. Сүргийн бүтцэд ямаа 46.4 хувийг, хонь 39.8 хувийг, үхэр 3.8 хувийг, адуу 7.3 хувийг, тэмээ 2.7



хувийг тус тус эзэлж байна. Мал сүргийн бүтцэд ямаа ихэнх хувийг эзэлсэн хэвээр байгаа боловч өмнөх онтой харьцуулахад ямааны эзлэх хувь 2.8 пүнктээр буурч, үлдэх 4 төрөл дээр 0.1-1.9 пүнктээр нэмэгджээ.


Мандах, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумаас бусад сумдад малын тоо өмнөх оноос өсчээ. Хамгийн олон мал тоолуулсан эхний 5 суманд Хатанбулаг, Дэлгэрэх, Улаанбадрах, Хөвсгөл, Даланжаргалан сумд орж байна.

Аймгийн хэмжээгээр 1000 –аас дээш малтай малчин өрхийн тоо 78 болж өмнөх оноос 30 өрх буюу 62,5 хувиар нэмэгджээ. 1000 –аас дээш малтай өрх Дэлгэрэх суманд 17, Өргөн суманд 12, Иххэт суманд 8, Хатанбулаг суманд 5 тоологдсон нь хамгийн олон нь байна. Харин 2000-3000 малтай өрх Хатанбулаг суманд 1, 3000-аас дээш малтай өрх Сайншанд суманд 1 тоологджээ.

2010 онд аминдаа малтай өрх 4460 байгаагийн 3395 нь буюу 76.1 хувь нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж байгаа малчин өрх байна. Нэг малчин өрхөд 276, малтай нэг өрхөд 231 толгой мал ногдож байгаа нь 2009 оноос малтай нэг өрхөд ноогдох мал 5 толгой малаар буурчээ.

2010 онд оны эхний хээлтэгчийн 63.1 хувь буюу 282.0 мянган эх мал төллөж, гарсан төлийн 98.5 хувь буюу 283.7 мянган төл бойжжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад төллөсөн хээлтэгч 14.9 хувиар, бойжсон төл 17.1 хувиар буурлаа. Бойжуулсан төлийн тоо өмнөх оноос ботгоноос бусад 4 төрөл тус бүр дээр буурсан байна. Эм хонины 73.2 хувь, үнээний 71.9 хувь, гүүний 67.5 хувь, эм ямааны 54.3 хувь, ингэний 53.0 хувь нь төллөв. Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл суманд эх малын төллөлтийн хувь хамгийн бага буюу 24.9-57.2 хувь байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, мянган толгойгоор, 2007-2010 он



2009 - 2010 онд өвөлжилт, хаваржилтын байдал хэвийн биш, зарим сумдад ихээхэн бэрхшээлтэй байлаа. 2010 онд 51.3 мянган том мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 4.8 хувьтай тэнцэж байна. Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Мандах сумдад хорогдсон малын тоо нийт хорогдлын 81.9 хувьтай тэнцэж байна.

2010 оны мал тооллогоор цэвэр үүлдрийн 12.1 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн 239.4 мянга, нутгийн шилдэг омгийн 112.4 мянган мал тоологдов. Өнгөрсөн онтой харьцуулахад цэвэр үүлдрийн мал 0.2 хувиар, нутгийн шилдэг омгийн мал 5.5 хувиар, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 1.3 хувиар тус тус өсчээ. Нийт малын 1.1 хувийг цэвэр үүлдрийн, 22.6 хувийг сайжруулсан нутгийн үүлдрийн, 10.6 хувийг нутгийн шилдэг омгийн мал эзэлж байна.

2010 онд нийт 41.9 га талбайд төмс, 48.6 га-д хүнсний ногоо тариалж, 161.6 тн төмс, 170.1 тн хүнсний ногоо хураан авлаа. Өмнөх оныхоос хураан авсан төмс 22.1 тн-оор бага, хүнсний ногоо 25.5 тн-оор илүү байгаа бол 1 га-аас 3.5-3.8 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2009 оноос төмс 1.0 тн, хүнсний ногоо 0.3 тн нэмэгджээ.

Тайлант онд малчид өөрсдийн хүч, нөөц бололцоогоор 1619.1 тн өвс хадлан 131.2 тн гар тэжээл, 99.3 тн хужир шүү болон бусад тэжээл бэлтгэсэн мэдээ ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 27.5 хувиар нэмэгдэж, гар тэжээл 47.4 хувиар буурсан байна. Бэлтгэсэн өвсний 162.0 тн буюу 10.0 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 1457.1 тн буюу 90.0 хувийг малчид, иргэд бэлтгэсэн байна.



2010 онд 172 гахай, 286 шувуу тоологдсон нь өмнөх оноос 78 ба 47 толгойгоор тус тус буурчээ. Тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрхүүд 7.45 тонн гахайн мах бэлтгэж 60.2 сая төгрөгийн борлуулалт, мөн 12.4 мянган ширхэг өндөг бэлтгэж 3120.5 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна

2010 онд 48 худаг шинээр гаргахад 272.5 сая төгрөг зарцуулсны 58.5 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 12.9 хувийг малчдын хамтын хөрөнгөөр, 28.6 хувийг олон улсын төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрээс санхүүжүүлжээ. Шинээр гаргасан худгийн тоо өмнөх оныхоос 16-аар цөөн байна.

2010 онд нийт 365 худаг сэргээн засварласны 342 нь энгийн уурхайн, 23 нь инженерийн хийцтэй бөгөөд худгийн засвар шинэчлэлтэнд нийт 208.6 сая төгрөг зарцуулав. Үүний 0.6 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 31.8 сая төгрөгийг малчид иргэдийн хөрөнгөөр, 176.2 сая төгрөгийг гадаадын болон олон улсын төсөл хөрөнгөөр засварласан байна.

Энэ онд малжуулах арга хэмжээнд 162 өрхийг хамруулж нийт 6319 толгой мал олгосны 96.4 хувь нь бог мал байв. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 18 өрхөөр буурч нэг өрхөд дундажаар 39 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 8 толгойгоор цөөн байна.

Малжуулалтанд 180.8 сая төгрөг зарцуулсны 24.7 хувийг гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 58.3 хувийг орон нутгийн хөрөнгөөр, 97.8 хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ. Гадаадын болон олон улсын төсөл хөрөнгийн санхүүжилт өнгөрсөн оноос 20.1 сая төгрөгөөр буурчээ.


Нийт малчин өрхийн 85.8 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 64.0 хувь нь телевизиртэй, 32.3 хувь нь автомашинтай, 49.8 хувь нь мотоциклтой өрх байна. Энэ нь өмнөх оныхоос цахилгааны эх үүсгүүртэй өрх 40.8 хувиар, телевизортой өрх 47.8 хувиар, автомашинтай өрх 23.8 хувиар, мотоциклтой өрх 39.4 хувиар нэмэгджээ.

## **2. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан болно. 2008 оноос эхлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцож байна.

Аж үйлдвэрийн салбарт оны үнээр 2.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 3.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлууллаа. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өнгөрсөн оноос 71.0 хувиар, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 38.4 хувиар тус тус нэмэгдсэн байна. Вакуум цонх, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлтийн өсөлт голлон нөлөөжээ.


*Зураг. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, 2005-2010 он*






Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 51.8 хувиар өссөн байна.

**Зураг. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн бүтэц, хувиар, өмчийн төрлөөр,**



**Зураг. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн бүтэц, хувиар, аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр**



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 86.7 хувийг төрийн өмчийн ААНБ, 13.3 хувийг хувийн өмчийн ААНБ үйлдвэрлэсэн байна.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 86.7 хувь, компани 10.8 хувь, хоршоо 0,03 хувь, өрхийн аж ахуй 2.5 хувийг тус тус үйлдвэрлэжээ.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан 28 гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс вакуум цонхны үйлдвэрлэл 9 дахин, жижиг төмөр эдлэл 8 дахин, блок үйлдвэрлэл 52.9 хувь, оёдол 38.0 хувь, модон эдлэл 32.8 хувь, дулаан 25.5 хувь, архи 24.6 хувь, зайрмаг 21.0 хувь, цахилгаан 5.1 хувиар өсч, бусад гурил, мах, талх, нарийн боов, ундаа, хиам гэсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан байна.


Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 1.6 хувь нь уул уурхай үйлдвэрлэлт, 11.8 хувь боловсруулах аж үйлдвэрлэлт, 86.6 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлт, усаг хангамжийн салбарт ногдож байна. Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь авч үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 86.7 хувь, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.4 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 8,9 хувийг тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо өмнөх оноос 19.9 хувиар нэмэгджээ. Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж 6.6 мян.төг болж өмнөх оноос 2.0 мян.төг буюу 42.6 хувиар нэмэгджээ.


### **3.Барилга үгсралт, их засвар**

2010 онд 78 объектод нийт 25325.5 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийгдэж байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.5 дахин нэмэгдсэн мэдээлэлтэй байна. Нийт 25325.5 сая төгрөгийн хөрөнгө оруулсны 10.8 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 6.5 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 0.4 хувийг яамдуудын хөрөнгө оруулалтаар, 2.3 хувийг замын сангийн хөрөнгө оруулалтаар, 59.5 хувийг азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар, үлдэх 20.5 хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Зураг. Барилга угсралт их засварын ажил, санхүүжилтийн бүтэц, хувиар, эх үүсвэрээр



Зураг. Барилга угсралт, их засварын ажил, мян.төг




Шинэ барилга, өргөтгөл шинэчлэлд 23.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсны 9.5 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 6.7 хувийг орон нутгийн төсвийн, 0.5 хувийг яамдуудын хөрөнгө оруулалтаар, 0,1 хувийг замын сангийн хөрөнгө оруулалтаар, 63.6 хувийг азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ. Нийт барилга угсралт, их засварын ажлын 12.0 хувийг аймгийн харьяа барилгын гүйцэтгэгч байгууллагууд гүйцэтгэжээ.

2010 онд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 1728.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий Саран хөхөө театрын, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 639.8 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, хувийн хөрөнгө оруулалтаар 835.9 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 60 айлын орон сууц, Монгол улсын хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 739.9 сая төгрөгийн үндсэн фонд бүхий Саруул дэнж хороололын зам, хувийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд 300 сая төгрөгийн үндсэн фонд бүхий үйлчилгээний төвийн барилга, 469 сая.төгрөгийн үндсэн фонд бүхий зочид буудлын барилга зэрэг нийт 4917.0 сая.төгрөгийн үндсэн фонд бүхий 20 гаруй барилга объектыг ашиглалтанд хүлээлгэн өгчээ.

Одоо Замын-Үүд суманд 150 хүүхдийн цэцэрлэг, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн албаны Замын-Үүд суман дах салбарын контор, Чөлөөт бүсийн контор, 96, 66, 48, 35, 8, 48 айлын орон сууц, Сайншанд суманд 920 хүүхдийн дунд сургууль, 65 айлын орон сууц, Ёс заншил, өв соёл, хүндэтгэлийн ордон, Онцгой байдлын газрын контор, Ардчилсан намын байр зэрэг томоохон барилгын ажил үргэлжилж байна.

Зураг. Барилга угсралт, их засварын ажлын жигд ажиллагаа, сараар, мянтөг,





#### **4.Тээвэр, Холбоо**

2010 онд 68.4 мянган тонн ачаа тээвэрлэж, 75.5 мянган тн.км-ийн ажил гүйцэтгэсэн, 67.5 мянган зорчигч тээвэрлэж 4017.3 мян.хүн.км-ийн ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 692.5 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5 дахин өсчээ.

2010 оны автотехникийн улсын үзлэг тооллогоор нийт 5625 авто машин, тээврийн хэрэгсэл тоологдсон нь өмнөх оноос 20.1 хувь буюу 940-оор нэмэгджээ. Нийт авто машины 53.6 хувийг суудлын, 24.3 хувийг ачааны автомашин, 2.8 хувийг автобус, 10.2 хувийг мотоцикл, 1.2 хувийг тусгай зориулалтын автомашин, 7.2 хувийг чиргүүл, 0.6 хувийг механизмуд эзэлж байна. Нийт тоологдсон авто техникийн 65.0 хувь нь иргэдийн хувийн өмчид байна. Харин 2010 оны жилийн эцсийн мал тооллогоор малчин өрхүүдэд тоологдсон мотоциклын тоог автотехникийн улсын үзлэг тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд аймгийн хэмжээний мотоциклийн 34.1 -ээс дээш хувь нь улсын үзлэг, тооллогод хамрагдсангүй гэж харагдаж байна.

Шуудан, холбооны үйлчилгээний орлого 238.4 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 30.2 хувиар буурсан байна. (Үүрэн телефон үйлчилгээний орлого ороогүй) Энэ нь үүрэн телефоны салбаруудын цэгийн болон хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, суурин холбооны үйлчлүүлэгчдийн тоо эрс буурсантай холбоотой юм. Суурин телефон цэгийн тоо өнгөрсөн оноос 15.0 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 4 кабелийн телевизийн цэг ажиллаж нийт 82.9 сая төгрөгийн орлого оруулж, 1900 гаруй хэрэглэгчдэд үйлчилж байна.

2010 онд аймгийн хэмжээгээр үүрэн телефоны оператор 5, компанийн салбар ажиллаж байгаагаас мобикомын 10, скайтелын 12, юнителын 11, F-zoni – 2, G-mobile-9, нийт 53 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлж байна. Үүрэн телефоны салбарууд 2010 онд нийт 2783.4 сая төгрөгний орлоготой ажилласан нь өнгөрсөн оны энэ үеэс 36.0 хувиар нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээгээр үүрэн телефон хэрэглэгч 34.3 мянга байгаа нь өмнөх оны энэ үеэс 4.3 мянган хэрэглэгчээр өсчээ.

#### **5. Дотоод худалдаа, Орон сууц, нийтийн аж ахуй**

Статистикийн бизнес регистрийн санд бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 281 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэйгээс 57.2 хувь нь хэвийн үйл ажиллагаа явуулж, 8.8 хувь нь үйл ажиллагаа бүрэн зогсоосон, 16.3 хувь нь түр зогсоосон, 13.2 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, үлдэх 4.5 хувь нь бусад шалтгаанаар үйл ажилаагаа явуулаагүй гэсэн дүн мэдээ байна.

Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын орлого 37524.5 сая төгрөгт хүрч өмнөх оноос 72.6 хувиар өссөн байна. Өмнөх оноос өссөн шалтгаан нь НИК ХК-ны салбар Өмнөговь аймгийн цагаан толгой, оюу толгой, говь уул уурхайнуудад нийлүүлэлт хийж байгаа нь нөлөөлжээ.

Зочид буудлын салбарын орлого 451.7 сая төгрөг, зоогийн газрын салбарын орлого 480.9 сая төгрөг болж өмнөх оноос 27.0-55.0 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээгээр 12.4 мян.м<sup>2</sup> талбай бүхий орон сууцыг шинээр ашиглалтанд оруулсан нь 2009 онтой харьцуулбал 52.6 хувиар өссөн байна.

Хот, нийтийн аж ахуйн үзүүлэлтийг өмнө онуудад зөвхөн сумын төв, суурин газруудын мэдээллээр харуулдаг байсан бол 2010 оноос аймгийн дүнгээр мэдээлдэг боллоо.


2010 онд гүний худаг 329, ус түгээх цэг 46, цэцэрлэгт хүрээлэн 13, хөшөө баримал 48, гэрэлтүүлэгтэй гудамж талбай 23.8 км болжээ.

Өмнөх оноос халуун усны газар 3.3 хувиар, хог тээврийн машины тоо 14.2 хувиар буурсан байна.

## **6. Боловсрол, соёл**

2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 20 сургуульд 10940, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЭМШУИС-ийн салбар сургуульд 1793 нийт 12733 оюутан сурагч суралцаж байна. Энэ нь өмнөх оны тооноос 1.7 хувиар буюу 214-өөр буурсан байна.

Зураг. Суралцагсад, элсэлт, төгсөлт. 2001-2010 он



ЕБС-ийн 1, 7, 10-р ангиудад нийт 3334 сурагч элсэн орсон байна. 2010-2011 оны хичээлийн жилд ЕБС-д 366 бүлэгт 10940 сурагч суралцаж, 531 багш ажиллаж багш хангалтын түвшин 98.7 хувьтай байна. Бага боловсролын 205 бүлэгт 5967 сурагч, суурь боловсролын 122 бүлэгт 3690 сурагч, бүрэн дунд боловсролын 39 бүлэгт 1283 сурагч сурч байна.

Нэг багшид ногдох хүүхдийн тоо 21 болж өнгөрсөн хичээлийн жилийнхээ түвшинд байна.

ЕБС-ийг бага, дунд, суурь боловсролоор 3504 сурагч төгсчээ. Сурагчдын сурлагын стандарт хангалт 97.0 хувь, А.В үнэлгээний эзлэх хувь 48.0 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулбал 1.0-1.3 пунктээр өслөө.

ЭМШУИС-ийн салбар сургуульд 200 оюутан элсэн орсны 146 их эмч, бусад дээд мэргэжлээр, 54 эм зүйч мэргэжлээр элссэн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 12 мэргэжлээр 437 хүүхэд шинээр элсүүлж 843 оюутан суралцагчтайгаар хичээллэсэн бол мэргэжлийн түр сургалтын төв буюу жолооны курст 491 иргэн суралцжээ.

## **7. Хүн амын эрүүл мэнд**

Дорноговь аймгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн бүх шатны 87 байгууллага, 856 хүн ажиллаж байна. Үүний дотор 210 их эмч, 88 эх баригч, бага эмч, 185 сувилагч ажиллаж байна. Нэг их эмчид 285 хүн, 1 сувилагчид 323 хүн ногдож байна.

2010 онд эмнэлэгийн орны тоо 366 болж 2.8 хувиар өслөө. 13.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсний 46.7 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 5.3 хувь нь хувийн өмчийн эмнэлэгүүдэд хэвтэж эмчлүүлжээ.

Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэлх насандаа 24 хүүхэд эндсэн нь өмнөх оны мөн үеэс 4-өөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

395.6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар, 13.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өсчээ.



Халдварт өвчнөөр 1266 хүн өвчилж халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувиар нэмэгдлээ. Үүний дотор БЗХӨ-өөр өвчлөгсдийн тоо нэмэгдэв. Он гарсаар 1468 эх жирэмсний хяналтанд орсон нь өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар илүү байна. Жирэмсний хяналтанд орсон эхчүүдийн 82.0 хувь нь эхний 3-н сартайдаа хяналтанд хамрагджээ. Өөрөөр хэлбэл 18.0 хувь нь хугацаанаасаа хожимдож эмнэлгийн хяналтанд оржээ.

Түргэн тусламжийн 22.6 мянган дуудлага ирсний 16.4 хувь нь алсын дуудлага байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 10.8 хувиар, алсын дуудлага 2.8 хувиар нэмэгдэв.

### **8. Нийгмийн халамж, нийгмийн даатгал**


“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн тухай” УИХ-ын 99 дугаар тогтоолын дагуу 56.9 мянган иргэнд 6112.6 сая төгрөгийн хишгийг хүртээжээ.

2010 оны байдлаар жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1362 эхчүүдэд 331.8 сая төгрөг, алдар цолтой 38 ахмадад 86.6 сая төгрөг, алдарт эхийн одонтой 2908 эхэд 340.5 сая төгрөгийн тэтгэмж, тусламжийг улсын төсвөөс олгожээ. Нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 777.3 сая төгрөгийг зарцуулсныг өнгөрсөн онтой харьцуулбал 25.5 хувиар нэмэгдлээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 9456.0 сая төгрөгт хүрч өмнөх оноос 20.4 хувиар нэмэгдлээ. Бүтцийг нь авч үзвэл 51.1 хувь нь ажил олгогчоос, 43.1 хувь нь даатгуулагчаас, 5.8 хувь нь бусад даатгуулагчаас бүрдсэн байна.

2010 онд нийт 9509.3 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжид олгосон ба үүний дотор тэтгэвэрийн даатгалын сангаас 6821.9 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 634.5 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 504.0 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжийн сангаас 498.0 сая төгрөгийн тэтгэмж тус тус олгожээ.

*Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая. төгрөгөөр*



ЭМД-ийн сангаас эмчилгээ үйлчилгээний зардалд 1050.9 сая төгрөгийг эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад олгожээ.

*Зураг. Нийгмийн даатгалд даатгуулсан ААНБ-ын тоо, төрлөөр*



Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо өмнөх оноос 0.1 хувиар буурч, 13,7 мянга болжээ. Үүнд: аж ахуйн нэгжийн даатгуулагчдын тоо 8.3 мянга болж 0.8 хувиар буурч, төсөвт байгууллагын даатгуулагчдын тоо 5.4 мянга болж 1.0 хувиар өсчээ.



Даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өмнөх оноос 5.9 хувиар өсчээ.

### **Дөрөв. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН**

Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) тооцоог 2007 оноос Сангийн сайд, ҮСГ-ын даргын 2006 оны 129\376 тоот тушаалаар батлагдсан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын шинэчилсэн ангилалын дагуу 19 салбараар тооцож байна.

2010 онд ДНБ оны үнээр 57.8 тэрбум төгрөг болж 2009 оныхоос 14.3 хувиар буюу 7.3 тэрбум төгрөгөөр өслөө. Нэг хүнд ногдох ДНБ 2010 онд 966.4 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 91.2 мянган төгрөгөөр өсөв.

ДНБ-ний өсөлтийн 4.9 нэгжийг хөдөө аж ахуйн салбар, 1.1 нэгжийг үйлдвэрлэлийн салбар, 8.3 нэгжийг үйлчилгээний салбар тус тус хангасан байна.

ДНБ-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 34.7 хувийг хөдөө аж ахуй, 13.5 хувийг тээвэр агуулахын үйл ажиллагаа, 9.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа, 7.5 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 10.3 хувийг боловсрол, 9.4 хувийг төрийн удирдлага батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа, 15.0 хувийг бусад салбар тус тус эзэлж байна. ДНБ-д эзлэх хувийн жингээрээ бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах, тээвэр агуулах, байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх, мэдээлэл холбоо, санхүүгийн болон даатгал, үл хөдлөх хөрөнгө, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, захиргааны болон дэмжлэг үзүүлэх, хүний эрүүл мэнд, урлаг үзвэр, тоглоом наадам, үйлчилгээний бусад үйл ажиллагаа гэсэн салбарууд 6.3 пунктээс 1 дахин өсч, бусад салбар 82.6-16.8 пунктээр буурсан байна.

### **Тав. ТӨСӨВ, МӨНГӨ, ЗЭЭЛ ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ**

#### **1. Төсөв, мөнгөн гүйлгээ**

2010 онд орон нутгийн төсөвт 8713.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 101.0 хувиар, 5010.0 сая төгрөгийн зарлагыг санхүүжүүлж төлөвлөгөөг 99.9 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн төсвийн орлогын 95.9 хувийг татварын, 3.9 хувийг татварын бус, 0.2 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Сайхандулаан сумаас бусад нь 100.9 – 113.5 хувиар биелүүлсэн байна.

*Зураг. Улсын төсвийн зарлага, Орон нутгийн төсвийн орлого, зарлага, 2005-2010 он, сая.төг*





Улсын төсвийн байгууллагуудын 15965.8 сая төгрөгийн зарлагыг санхүүжүүлсний дотор цалин хөлс ба нэмэгдэл урамшил 55.2 хувийг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5.4 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал 35.9 хувийг, татаас ба урсгал шилжүүлэг 3.5 хувийг тус тус эзэлж байна.

Улсын төсвийн зарлагын 87.1 хувийг улсын төсвийн санхүүжилтээр, 7.7 хувийг өөрийн орлогоос, 5.3 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус санхүүжүүлжээ.


Улсын нэгдсэн төсөвт хүн амын орлогын албан татвар, ААНБОАТатвар, ашигт малтмалын нөөц ашигласны татвар, онцгой албан татварын орлого нийт 1240.0 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 104.4 хувиар биелүүллээ.

## **2. Банк, мөнгө, зээл**

Дорноговь аймагт ХААН, ХХБанк, Голомт банк, ХАС банк, Хадгаламж банк нийт 38 тооцооны салбар төвүүд үйл ажиллагаа явуулж байна.


Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 151.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 18.2 хувь, цэвэр зарлага 135.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 16.2 хувиар тус тус өссөн байна. Цэвэр орлого нь зарлагаас 11.9 хувиар их байна.

*Зураг. Хадгаламж эзэмшигчид, зээлдэгчийн тоо, 2010 он, сар бүрээр, мян.хүн*



Иргэдийн мөнгөн хадгаламж 12.4 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дундажаар 207.9 мянган төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид дундажаар 481.2 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 6.8 хувь, хадгаламжийн үлдэгдэл 37.4 хувиар тус тус өсчээ.

*Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2010 он, сар бүрээр, сая.төг*





Иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн үлдэгдэл 27410.9 сая төгрөг болж өмнөх оныхоос 62.0 хувиар нэмэгдсэн ч хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 60.8 хувиар буурч, зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь 1.10 хувьд хүрч өмнөх оноос 3.4 функтээр буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

### **3.Үнэ**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2010 онд суурь үнээс (2005 оны 12-р сар) 82.3 хувь, 2009 оны жилийн эцсээс 7.3 хувь, өмнөх сар буюу 2010 оны 11-р сараас 1.5 хувиар тус тус өссөн байна. Ерөнхий индекс өмнөх сарынхаас 1.5 хувь өссөн нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2.4 хувь өссөний дотор хонины мах 12.0 хувь, адууны мах 8.0 хувь, ямааны мах 12.5 хувь, лууван 6.7 хувь, сонгино 6.7 хувь, ургамлын тос 1.2 хувь, шар будаа 2.5 хувь, жигнэмэг 5.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 3.4 хувиар өссөний дотор нүүрсний үнэ 9.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 6.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

#### Хүснэгт1.


Бараа, үйлчилгээний бүлэг	ЖИН	2010 -12 2005-12	,2010-12 ,2009-12	,2010-12 ,2010-11
<b>ЕРӨНХИЙ ИНДЕКС</b>	<b>1.0000</b>	<b>182.3</b>	<b>107.3</b>	<b>101.5</b>
ХҮНСНИЙ БАРАА, УНДАА, УС	0.3169	178.4	110.5	102.4
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ	0.3088	232.3	102.1	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.0081	154.7	104.5	101.2
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ТҮЛШ	0.0329	231.1	113.7	103.4
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.2101	191.3	104.9	102.2
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.0055	159.6	100.1	100.4
ТЭЭВЭР	0.1152	198.9	98.7	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.0126	82.3	95.9	100.0
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.0275	123.1	100.1	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.0986	241.3	113.6	100.0
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.0200	154.2	100.3	100.0
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.0309	157.9	117.4	106.5

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тээвэр, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийнх 2.3-4.3 хувиар буурч, эдгээрээс бусад бүлгийн үнэ 0.1 -17.4 хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт1)

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ өмнөх оны мөн үетэй /2009 оны 12-р сар/ харьцуулахад 10.5 хувь өссөний дотор хамгийн өндөр өсөлттэй нь ямааны мах 43 хувь, хонины мах 40.0 хувь, адууны мах 35.0 хувь, үхрийн мах 30.0 хувь, цагаан будаа 25.0 хувь, төмс 25.0 хувь өссөн байна. Энэ бүлгийн нийт 54 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний 59.3 хувийнх нь үнэ 1.3 - 43.0 хувиар өсчээ. Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 13.7 хувь өссөний дотор цэвэр, бохир усны үнэ 2 дахин, халаалтын үнэ 23.7 хувь, 1 квт цахилгааны үнэ 17.2 хувь, 1 шуудай түлшний модны үнэ 40.0 хувиар тус тус өссөн байна.




**Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2010 оны 12-р сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)**



2010 оны 12-р сарыг 2009 оны 12-р сартай харьцуулахад хэрэглээний сагсан дах 194 бараа, үйлчилгээний 40.2 хувийнх нь үнэ өсч, 14.4 хувийнх нь үнэ буурч, 45.4 хувийнх нь үнэ тогтвортой байсан нь үнэ тариф өсөлттэй байсан сард тооцогдож байна.

**Зураг. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс, 2008 - 2010 оны сар бүрээр (өмнөх оны 12-р сар=100)**



### **Зургаа. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО**

Статистикийн бизнес регистрийн санд 2010 оны жилийн эцсийн байдлаар 705 аж ахуйн нэгж бүртгэгдсэний 459 буюу 65.1 хувь хэвийн үйл ажиллагаа явуулж 34.9 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, түр зогссон байна. 2010 онд 94 аж ахуй нэгж шинээр байгуулагдаж, 30 аж ахуйн нэгж татан буугджээ.

Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 2009 оныхоос 1.6 хувиар нэмэгдсэн боловч үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2.6 пүнтээр буурчээ.

Нийт аж ахуйн нэгжийн 39.8 хувь нь худалдааны салбарт, 9.4 хувь нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбарт, 7,5 хувь нь зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулж байна Хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, барилга,худалдаа, зочид буудал, зоогийн газар, агуулах, үл хөдлөх, эрүүл мэндийн салбарын аж ахуйн нэгжийн тоо 1.9-40.0 хувиар өсч, бусад салбарынх 3.9-33.3 хувиар буурсан байна.



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 73.8 хувийг 1-9 ажиллагчидтай, 14.2 хувийг 10-19 ажиллагчидтай, 8,7 хувийг 20-49 ажиллагчидтай, 3.3 хувийг 50-с дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж эзэлж байна.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 49.2 хувь нь Сайншанд суманд, 15.7 хувь нь Замын-үүд суманд ногдож байна.

## **Долоо. БУСАД**

### **1. Байгал орчны төлөв байдал**

Дорноговь аймгийн нийт газар нутгийн 88.6 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 8.9 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 1.4 хувийг ойн сан бүхий газар, 0.3 хувийг хот, тосгон, суурин газар, 0.4 хувийг зам, шугам сүлжээний газар, 0.2 хувийг усан сан бүхий газар эзэлж байна.

2010 онд аймгийн нийт газар нутгийн 0.002 хувь буюу 318.4 га газарт ямар нэг хэмжээний хохирол учруулжээ. 21.8 га газар ухагдаж эвдэрсэн ба энэ нь ашигт малтмалын олборлолтоос шалтгаалсан байна.

49.6 га газарт нөхөн сэргээлтийн ажил хийсэн бөгөөд үүнд 433.9 сая төгрөгийн зардал гаргажээ. Аймгийн хэмжээнд 2010 онд 44.4 мянган ш мод тарьснаас 73,6 хувь нь ургасан байна.

2010 оны эцэст ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБайгууллагын тоо 5.1 хувиар, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын тоо 6.4 хувиар нэмэгджээ.

Газар өмчлөх хүсэлт ирүүлсэн 198 өрхийн газар өмчлүүлэх шийдвэр гаргасан байна. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлсэн газрын хэмжээ 367.8 га байгаа нь өмнөх оноос 11.6 хувиар өссөн байна.

### **2. Цаг уур**

2010 онд агаарын температурын дундаж 3,9 градус дулаан байсан нь олон жилийн дунджаас(ОЖД) 0.3 градусаар, өнгөрсөн оноос 0.1 градусаар дулаан байлаа. Агаарын температур өдөртөө ихэнх нутгаар 6, 7 дугаар саруудад 38-40 градус хүрч халсан байхад агаарын үнэмлэхүй хамгийн бага температур 12, 1 дүгээр саруудад ихэнх нутгаар -28-32 градус хүрч хүйтэрсэн байна.

Хөрсний гадаргын жилийн дундаж температур 7.0 градус болж ОЖД-аас 2.0 градусаар дулаан, өнгөрсөн оноос 1.0 градусаар хүйтэн байжээ. Хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн их температур 6, 7, 8 дугаар саруудад ихэнх нутгаар 63-68 градус дулаан, хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн бага температур 12, 1 дугаар сард нутгийн ихэнх хэсгээр -36-40 градус хүрч хүйтэрсэн байна.

2010 онд нийт нутгаар 1484.7 мм тунадас орсон нь ОЖД-аас ахиу байв. Энэ оны 2, 8 дугаар саруудад ОЖД-аас бага харин бусад саруудад тухайн сарынхаа ОЖД-аас ахиу хур тунадас орсон байна. 6 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 20-ны хооронд нийт нутгаар 337.8 мм хур тунадас орсон нь ОЖД-аас харьцангуй их байлаа. Сайншанд, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Алтанширээ, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг сумдын зарим багийн нутгаар зуншлага сайн буюу хэвийн байв. Харин 7, 8 дугаар сард хур тунадас багатай, хэт халалт, хуурай салхитай байсны нөлөөгөөр ихэнх сумын нутгаар гандсан байна.

Жилдээ 127 өдөр шороон шуургатай байсны ихэнх нь буюу 61 хувь нь 3,4,5,12 дугаар сард ажиглагдаж энэ үеэр салхины хамгийн их хурд 18-24 м/с буюу аюулын хэмжээнд хүрч шороон болон цасан шуурга шуурчээ. Сүүлийн жилүүдэд 3-5 сард сарын 22-27 хоног шороон шуурга шуурч байгаагийн улмаас өнгөн хөрс салхинд хийсч ургамлын үндэс шороонд цохигдон элсний хуримтлал Иххэт, Айраг, Даланжаргалан, Алтанширээ, Дэлгэрэх сумдын нутгаар илүүтэй үүссэн мөн 7-8 сард олон хоног хурц нар гарч агаарт 38-40 хэм, хөрсөнд 56-69 хэм хүрч хэт халсан, энэ хугацаанд хур тунадас бага, хөрсний чийгшил




хурдан ууршиж байсны улмаас зуншлагатай байсан зарим нутгаар ургамал нэлээд гандсан байна.

Энэ зуны байдлаар бэлчээрийн ургамлын хөнөөлт хортон шавьж царцаа, мэрэгч амьтдын хэт олшролт ажиглагдаагүй болно.

### **3. Гэмт хэрэг**

Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр 2010 онд 521 гэмт хэрэг гарсан нь өмнөх оноос 58 буюу 10.0 хувиар буурлаа. Хэргийн өнгөөр үзвэл хүний амь бүрэлгэсэн гэмт хэрэг (9), хүчин (2), залилангийн (3) гэмт хэрэг өсч, бусад хэргийн тоо буурсан байна.

*Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 1999-2010 он*



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 38.4 хувийг ИЭЧЭМ-ийн эсрэг гэмт хэрэг, 19.6 хувийг өмчийн хулгайн хэрэг, 7.7 хувийг контервантын хэрэг, 1.3 хувийг онц хүнд гэмт хэрэг, 8.6 хувийг хүнд гэмт хэрэг эзэлжээ.

Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд сумдад гэмт хэргийн гаралт өсч бусад сумдад гэмт хэргийн гаралт буурлаа.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1179.0 сая төгрөгийн хохирол учирч, 23 хүн нас барж, 270 хүн гэмтэж бэртсэн байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ өмнөх оныхоос 35.9 хувиар, нас барсан хүний тоо 10-аар нэмэгдэж, гэмтэж бэртсэн хүний тоо 17.2 хувиар буурсан байна. Нийт хохирлын 66.1 хувийг эргэн төлүүлжээ.


Нийт гэмт хэргийн 38.8 хувийг согтуугаар, 9.8 хувийг бүлэглэн, 50.1 хувийг шөнө, оройн цагаар үйлдсэн байна. Хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 6-аар, эмэгтэйчүүд оролцсон гэмт хэргийн тоо 35-аар буурсан дүн мэдээ гарлаа. Тайлант хугацаанд нийт 2336 хүн эрүүлжүүлэгдсэн байна.

### **4. Бусад**

Аймгийн хэмжээнд 2010 онд их бага хэмжээний 24 гал түймэр гарч, 26.4 сая төгрөгийн хохирол учирч гал түймрийн улмаас 1 хүний амь үрэгджээ.

Нийт гарсан гал түймрийн 41.7 хувь нь цахилгааны угсралт, ашиглалтын буруугаас, 12.4 хувь нь иргэдийн хайхрамжгүй үйлдлээс, 4.2 хувь нь санаатай хэлбэрээр, 4.2 хувь нь архидаан согтуурснаас, 37.5 хувь нь зуух, пийшингийн зөрчлөөс үүдэлтэй гарчээ. Цахилгаан угсралт, ашиглалтын буруугаас, зуух, пийшингийн зөрчлөөс үүдэлтэй гарсан галын тоо өсч бусад шалтгаанаар үүссэн галын тохиолдол буурсан байна.

Онцгой байдлын хэлтэс тайлант онд 323 аж ахуйн нэгж, байгууллага, 1950 айл өрхөд гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг явуулжээ.





## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БАЙДАЛ



( 2006-2010 он )

### Эдийн засаг, нийгмийн зарим гол үзүүлэлтүүд

	2006	2007	2008	2009	2010	2010	2010
1. Суурин хүн ам, оны эцэст мян.хүн	54.0	53.6	55.6	57.7	59.8	110.7	103.6
- Төрсөн хүүхдийн тоо	1111	1247	1279	1438	1346	121.2	93.6
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор	349	279	311	289	349	100.0	120.8
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	762	968	968	1149	997	130.8	86.8
